



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны "Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" 243 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Цагаан шонхор" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг "Бөртэ" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлэх Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

Н.Ганболд

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Түвшинтөр

Батлан хамгаалах яамны Бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,
Хурандаа /Зөвшилцсөнөөр/

Л.Хосбаяр

Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү,
хөрөнгө оруулалтын газрын дарга
/Зөвшилцсөнөөр/

Б.Болормаа

Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү,
хөрөнгө оруулалтын газрын шинжээч
/Зөвшилцсөнөөр/

Н.Бат-Очир

Батлан хамгаалах яамны Бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах
мэргэжилтэн, Дэд хурандаа /Зөвшилцсөнөөр/

Б.Жавхлан Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн /Зөвшилцсөнөөр/

Д.Тунгалагтуул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Энхтайван "Бөртэ" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Ерөнхий захирал, Хурандаа

Н.Мөнх-Оргил "Цагаан шонхор" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал

Ц.Цэнгэлмаа "Цагаан шонхор" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч

Нарийн бичиг:


Б.Билгүтэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Алтантуяа "Бөртэ" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч

2.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.


3.Ажлын хэсгийн нэгдсэн санал, дүгнэлтийг 2022 оны 10 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг /Н.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын
15 өдрийн 15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг: Зорилго

“Цагаан шонхор” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Бөртэ” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлэх талаар цаашид авах арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл

1. “Цагаан шонхор” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эд хөрөнгийг 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан балансын дүнгээр “Бөртэ” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлэх;

2. Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үүссэн архивын баримтыг бүрдүүлэн Архивын ерөнхий газарт хүлээлгэн өгөх;

3. “Цагаан шонхор” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хаалтын балансыг гаргах;

4. “Цагаан шонхор” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хаалтын балансын /эд хөрөнгийг тоолж бүртгэх, өр авлагын тооцоо нийлэх гэх мэт/ дүнгээр “Бөртэ” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хүлээлгэж өгөх.

Гурав: Үр дүн, хугацаа

Ажлын хэсгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх санал дүгнэлтээ 2022 оны 10 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулах.

.....000.....